

ЗАСГИЙН ГАЗРЫН 2012 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Санхүү, төсвийн талаар

Үнэт цаасны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын гишүүдийн саналыг тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон.

Гашуунсухайт, Шивээхүрэнгийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2012 оны 107 дугаар тогтоолоор баталсан.

Иргэдэд олгох хувьцааны тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол гарав.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012-2016 онд хөгжүүлэх дунд хугацааны тэргүүлэх чиглэлийн тухай төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган УИХ-д өргөн мэдүүлэхээр боллоо.

Монгол Улсын 2013 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2012 оны 3 дугаар сарын гүйцэтгэлээр 1.048.8 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 117.2 тэрбум төгрөгөөр буюу 10.1 хувиар давж, улмаар 2011 оны мөн үеийнхээс 144.1 тэрбум төгрөгөөр буюу 15.9 хувиар өссөн.

Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага 2012 оны 3 дугаар сарын гүйцэтгэлээр 2.064.8 тэрбум төгрөг (үүнээс: улсын төсвийн зарлага 1.315.8 тэрбум төгрөг) зарцуулахаас гүйцэтгэлээр 1.104.8 тэрбум төгрөг (улсын төсвийн зарлага 825.8 тэрбум төгрөг)-т хүрч, төлөвлөсөн нэгдсэн төсвийн зарлагын 53.5 хувийг (улсын төсвийн зарлагын 62.8 хувийг) санхүүжүүлсэн гүйцэтгэлтэй гарлаа.

Хүний хөгжил санд 2012 оны 3 дугаар сарын гүйцэтгэлээр (өссөн дүнгээр) нийт орлого 92.1 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 32.2 хувиар буюу 53.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2012 оны 3 дугаар сарын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 182.8 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 56.0 тэрбум төгрөгийн алдагдалтай (үүнээс: улсын төсвийн урсгал тэнцэл 71.5 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 113.1 тэрбум төгрөгийн алдагдалтай) гарсан.

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 102 дугаар тушаалаар Хүний их эмч мэргэжлээр төгсөгчид тавигдах шаардлага, Нийгмийн эрүүл мэндийн мэргэжлээр төгсөгчидэд тавигдах шаардлага, Нүүр амны их эмч мэргэжлээр төгсөгчид тавигдах шаардлага, Уламжлалт анагаахын их эмч мэргэжлээр төгсөгчид тавигдах шаардлага, Эм зүйч мэргэжлээр

төгсөгчид тавигдах шаардлага, Бакалаврын зэрэгтэй сувилагчид тавигдах шаардлага, Дипломын зэрэгтэй сувилагчид тавигдах шаардлага, Туслах сувилагч мэргэжлээр төгсөгчид тавигдах шаардлагыг тус тус баталж, батлагдсан шаардлагыг анагаах ухаан, нийгмийн эрүүл мэнд, уламжлалт анагаах ухаан, нүүр ам судлал, эм зүй, сувилахуйн мэргэжлийн боловсролын стандартад тусган оруулахаар шийдвэрлэсэн.

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2012 оны 129/100 тоот хамтарсан тушаалаар “Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох журам”, “Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалт”-ыг тус тус баталж, “Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалт”-ын 2.4.4-т заасан эмийн төсвийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн төсөвт, 2.4.9-т заасан эмийн төсвийг Улсын клиникийн төв эмнэлгийн төсөвт, мөн 2.4.11-т заасан эмийн төсвийг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн жил бүрийн төсөвт улсын хэмжээний хэрэгцээг тооцон тусгахыг Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт даалгав.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2012 оны а-44/111 тоот хамтарсан тушаалаар “Монгол улсад зонхилон тохиолдож буй мэргэжлээс шалтгаалсан өвчин, эмгэгүүдийн оношлогоо, эмчилгээний удирдамж”-ийг баталж, хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт тус тус даалгав.

Нийгмийн хамгааллын талаар

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” сарын аяныг зарлав.

Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын хөтөлбөрт нийцүүлэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгжид ногдох зардлын дээд хэмжээг тогтоох тухай Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/41 тоот тушаалыг батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.

“Нийгмийн хариуцлагын тухай” ISO 26000 олон улсын стандартыг хэрэгжүүлэх асуудлаар Швейцарын хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төсөлтэй хамтран ажиллах “Санамж бичиг”-ийг байгууллаа.

Алслалтын болон говийн нэмэгдлийн талаар авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг бэлтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн барихаар боллоо.

“Орон гэргүй тэнэмэл иргэдийн талаар тулгамдаж буй асуудал” сэдэвт уулзалтыг холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулж, тодорхой бодлогын баримт бичиг боловсруулав.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол. Бага насны хүүхдийн хөгжлийн стандартыг хэрэгжүүлэх зорилгоор сургуулийн өмнөх боловсролын “Ахлах” бүлгийн сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн

даргын 2012 оны 142 дугаар тушаалаар байгуулан хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүлсний зэрэгцээ энэхүү стандартыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжид үнэлгээ өгөх, сайжруулан боловсруулах ажлын хэсгийг БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2012 оны 143 дугаар тушаалаар байгуулав.

Ерөнхий боловсролын сургуулийн математик, физик, биологи, химийн 6-8 дугаар ангийн хөтөлбөрийг олон улсын хөтөлбөртэй уялдуулан шинэчлэн боловсруулах багуудыг томилон ажилд нь оруулсны зэрэгцээ эдгээр хөтөлбөрийн төсөл, ажлын схемийг хянах багш, судлаачидтай гэрээ байгуулав.

Дээд болон мэргэжлийн боловсрол. Азийн хөгжлийн банк, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас хамтран хэрэгжүүлж буй “Мэдлэгт суурилсан нийгмийн төлөө дээд боловсролын шинэчлэл” техникийн туслалцааны төслийн “Төгсгөлийн шатны тайлан-семинар” (ажилбарт сургалт)-ыг зохион байгууллаа.

Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу Польш, Унгар, Румын, Болгар, Хорват улсад 2012-2013 оны хичээлийн жилээс элсүүлэн сургах суралцагчдын сонгон шалгаруулалтыг зарлан зохион байгуулав.

Соёл, урлаг. “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад нэмэлт оруулах тухай” Засгийн газрын 2012 оны 134 дүгээр тогтоолоор Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг үндэслэн Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээг тодорхойлох Мэргэжлийн зөвлөл тодорхойлсны дагуу Үндэсний номын санд хадгалагдаж буй монголын түүхийн үнэт баримтат өв болох гар бичмэл, ном судар 10, МУИС-ийн Улаанбаатар сургуульд хадгалагдаж буй эртний Хүннүгийн язгууртны эд өлгийн зүйлс 10, Эрдэнэ Зуу музейн сан хөмрөгт хадгалагдаж буй бурхны шашны ховор нандин дурсгал цутгамал бурхад, танка зэрэг 32, Чойжин ламын сүм музейд хадгалагдаж буй Занабазарын хийцийн цутгамал бурхад, модон сийлбэр, хатгамал зэрэг 25, нийт 77 ширхэг эд өлгийн зүйлсийг Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад нэмж бүртгэлээ.

“Хамгаалалтын бүс тогтоох тухай” Засгийн газрын 2012 оны 135 дугаар тогтоолоор түүх, соёлын хосгүй үнэт дурсгал болох Булган аймгийн Баяннуур сумын нутагт илэрсэн Хүннүгийн язгууртны дурсгалт цогцолбор газрын нийт хамгаалалтын бүсийг 133.6 га байхаар тогтоов.

Шинжлэх ухаан, технологи. “Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын оюуны өмчийн харилцааны асуудлууд” семинарыг ШУТИС, Оюуны өмчийн газар, ЮНЕСКО-гийн үндэсний комисстой хамтран зохион байгуулсны зэрэгцээ Монгол судлалыг хөгжүүлэх асуудлыг эрчимжүүлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор Монгол судлалын үндэсний зөвлөлийг БСШУ-ы сайдын 2012 оны 171 дүгээр тушаалаар батлав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр

Хаврын тариалалтын технологийн зөвлөмж, тариаланчдын дэвтрийг аймгуудад хүлээлгэн өглөө.

“Хөдөөг хоршоолох аян”-ны нээлтийн арга хэмжээг Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь,

Орхон, Хэнтий, Сүхбаатар, Хөвсгөл аймгуудад хийж, хоршооллын талаар төрөөс баримтлаж буй бодлого, ноосны урамшуулал, хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн бирж, жишиг хоршоо болон аяны хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа.

Оёдлын салбарын мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх 72 цагийн сургалтыг ШУТИС-ын Хувцас судлалын төвтэй хамтран зохион байгууллаа.

“Хувцас үйлдвэрлэл, оёдлын салбар дахь сургалт-үйлдвэрлэлийн уялдааг сайжруулах нь” онол, практикийн бага хурал зохион байгууллаа.

Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын “Хил дамжин тархах халдварт өвчнийг хянах, тэмцэх олон талт хамтын ажиллагаа” сэдэвт олон улсын семинарыг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран зохион байгуулав.

ОХУ-ын Засгийн газраас үзүүлж буй 375 сая рублийн буцалтгүй тусламжийн вакцины хоёр дугаар ээлжийн нийт 13.985 сая тунг хүлээн авлаа.

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын чиглэлээр

Гашуунсухайт, Шивээхүрэнгийн хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, Засгийн газрын 104 дүгээр тогтоолыг баталлаа.

Улаанбаатар хотын нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр байгуулах тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барихаар болсон.

Шинээр тавигдахаар төлөвлөж буй төмөр замын дагуу GPS-ийн сүлжээ байгуулах, 1:25000-ны масштабтай байр зүйн зураг зохиох ажилд явцын хяналт, шалгалт хийх ажлын техникийн даалгаврыг ЗТБХБ-ын яамны Төрийн нарийн бичгийн дарга баталлаа.

Берлин эко хотхоныг өөрийн хөрөнгөөр барилгажуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах ажлын хэсгийн удирдамжийг боловсруулан ЗТБХБ-ын яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлав.

Эрдэс баялаг, эрчим хүчний салбарын чиглэлээр

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ХБНГУ-д хийх айлчлалын үеэр Монгол улс, ХБНГУ хооронд байгуулсан “Ашигт малтмал, аж үйлдвэр болон технологийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангуулах Засгийн газрын хамтарсан ажлын хэсгийн анхдугаар хуралдаан ХБНГУ-д зохион байгуулагдав.

Засгийн газрын хуралдаанаар бичил уурхайн хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаарх өнөөгийн байдлыг танилцав.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.

ЭБЭХ-ний сайдын 2012 оны 41 дүгээр тушаалаар байгуулагдсан Оюутолгойн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн санхүүгийн тооцооны тодотголд дүгнэлт гаргах Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, “Оюутолгой” ХХК, “Эрдэнэс МГЛ” ХХК, “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн төлөөллүүдтэй санал солилцлоо.

Түүхий нүүрс олборлогч аж ахуйн нэгж, байгууллагад агаарын бохирдлын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх тухай журмын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн батлав.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

Байгаль орчны багц хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэв.

Орон сууцны хороолол түшиглэсэн ногоон байгууламжийн заавар боловсруулах ажлыг Монголын байгаль орчны иргэний зөвлөлөөс шалгаруулсны дагуу “Монголын ойчид-цэцэрлэгжүүлэлтийн холбоо” төрийн бус байгууллагатай гурвалсан гэрээ байгуулж, ажлыг эхлүүлэв.

“Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 1/1570 албан даалгавар, “Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” А-123 тушаал гаргав.

Монгол улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хилийн усны хамтарсан комиссын V хуралдааныг Улаанбаатар хотноо зохион байгуулав.

“Улаанбаатар хотын гэр хороололын ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн шийдэл” сэдэвт чуулганыг АCF-Монгол Олон улсын байгууллага, UNICEF, Усны газар хамтран зохион байгуулж зөвлөмж гаргав.

Гадаад харилцааны чиглэлээр

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүгд Найрамдах Киргиз Улс (БНКиру)-ын Ерөнхийлөгч А.Ш.Атамбаевын урилгаар 2012 оны 4 дүгээр сарын 3-6-ны өдрүүдэд тус улсад албан ёсны айлчлал хийв.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын Япон Улсад хийсэн айлчлалын дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулав.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын урилгаар Кентийн Хунтайж Майкл Монгол Улсад 4 дүгээр сарын 14-18-ны өдрүүдэд айлчлал хийв.

Монгол, Францын Гадаад харилцааны яам хоорондын зөвлөлдөх уулзалт 4 дүгээр сарын 10-нд Парис хотноо, Монгол, Туркийн Гадаад харилцааны яам хоорондын зөвлөлдөх уулзалт 4-р сарын 13-нд Анкара хотноо тус тус болов.

Гадаад худалдааны цахим систем бүрдүүлэх төслийн хүрээнд байгуулсан Эрх зүйн орчны дэд ажлын хэсгийн хуралдааныг 4 дүгээр сарын 6-ны өдөр зохион байгуулав.

Хууль зүйн чиглэлээр

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2014-2015 оны төсвийн төсөөллийн тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Татварын ерөнхий хууль болон холбогдох заримд хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай зэрэг хуулийн төслийн үзэл баримтлалыг хянан батлав.

Барилгын зарим нэр төрлийн материалын гаалийн татварыг нэмэгдүүлэх тухай УИХ-ын тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг хянан баталсан.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл олголоо.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан ажлын хэсэг Дотоод хэргийн их сургуулийн элсэлтийн журмыг боловсруулав.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлав.

Батлан хамгаалах салбарт

Өмнөд Судан улс дахь НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын хооронд “Харилцан ойлголцлын санамж бичиг” баталгаажуулах, түүнд гарын үсэг зурах эрх олгох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн.

”Монгол Улсын Төрийн батлан хамгаалах бодлогын үзэл баримтлал” баримт бичгийн шинэчилсэн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн.

Батлан хамгаалахын сайдын 2012 оны А/134 дугаар тушаалын дагуу АНУ-ын БХЯ-ны “Батлан хамгаалах байгууллыг шинэчлэх санаачлага” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа “Нөөцийн удирдлага, зохицуулалт”, “Цэргийн мэргэжлийн боловсрол” сэдэвтэй 9 дэх удаагийн хамтарсан семинарыг Батлан хамгаалахын их сургуулийг түшиглэн зохион байгууллаа.

Дайчилгааны бэлтгэл нөөцийн I, II зэргийн бэлтгэл үүрэгтэн мөн I зэргийн бэлтгэл үүрэгтэн бэлтгэл офицеруудын сургалтуудад дэмжлэг үзүүлэх Говьсүмбэр, Сүхбаатар, Баян-Өлгий, Хэнтий, Дорнод, Говь-Алтай, Орхон аймгуудад Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний I зэргийн бэлтгэл үүрэгтний сургалт, Говьсүмбэр, Орхон аймгуудад Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний II зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтууд зохион байгуулагдав.

НҮБ-ын болон Олон Улсын ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн багуудад 471 ЦАХ /Афганистан-343, Судан-Дарфур-68, Өмнөд судан-60/ НҮБ цэргийн ажиглагч болон штабын офицероор 21 ЦАХ /MONUSCO-2, MINURSO-4, UNMISS-8, UNAMID-2, UNAMA-1/, АНУ-ын төвийн командлалд суугаа холбогчдын багт 3 ЦАХ, НҮБ-ын дэргэд суугаа байнгын

төлөөлөгчийн газрын дэргэдэх цэргийн зөвлөх 1 ЦАХ, Монгол Улсын Зэвсэгт хүчнээс гадаадад нийт 492 ЦАХ үүрэг гүйцэтгэж байна.

НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд шаардагдах техник, материал хэрэгслийг бэлтгэн нийлүүлэх ТМХ-2012/002 тендерийн нээлтийг хийж, шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагын зөвлөмжийг хийж, гэрээ байгууллаа.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР